

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмж (UPR)

№	Recommendations by UN Human Rights Council upon consideration of the first national report of Mongolia under Universal Periodic Review in 2010	Хүний эрхийн төлөв байдлын тухай Монгол Улсын үндэсний анхдугаар илтгэлийг 2010 онд хэлэлцээд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс өгсөн зөвлөмж
1.	84.1 Ratify, at the earliest possible date, the International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance (France)	84.1 Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийг аль болох ойрын хугацаанд соёрхон батлах (Франц Улс)
1.	84.2. Favourably consider the possibility of the ratification of the Optional Protocol to the Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (Mexico)	84.2. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах боломжийг нааштайгаар авч үзэх (Мексик Улс)
1.	84.3. Ratify the Optional Protocol to the Convention against Torture and other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, and introduce effective mechanisms for monitoring the actions of law enforcement officials (New Zealand)	84.3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг соёрхон батлах, хууль хяналтын ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих үр дүнтэй механизмыг нэвтрүүлэх (Шинэ Зеланд Улс)
1.	84.4. Ratify the Optional Protocol to the Convention against Torture, and the International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance, and make the declaration provided for in article 22 of the Convention against Torture (Spain)	84.4. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцийг тус тус соёрхон батлах, Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 22 дугаар зүйлийн дагуу мэдэгдэл гаргах (Испани Улс)
1.	84.5. Become party to the Optional Protocol to the International Covenant on Economic, Social and Cultural Rights (Argentina)	84.5. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколд нэгдэн орох (Аргентин Улс)
1.	84.6. Become party to the International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance (Argentina)	84.6. Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенцид нэгдэн орох (Аргентин Улс)
1.	84.7. Ratify the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights (Brazil) (Spain)	84.7. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II Протоколыг соёрхон батлах (Бразил Улс, Испани Улс)
1.	84.8. Sign and ratify the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights, aiming at the abolition of the death penalty (Sweden) (Portugal)	84.8. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколд гарын үсэг зурж, түүнийг соёрхон батлах (Швед Улс, Португал Улс)
1.	84.9. Ratify relevant international instruments, including the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights, aiming at the abolition of the death penalty, and take the necessary steps to remove the death penalty from Mongolia's justice system (Australia)	84.9. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протокол зэрэг холбогдох олон улсын баримт бичгүүдийг соёрхон батлах, Монгол Улсын эрх зүйн тогтолцооноос цаазаар авах ялыг халахад шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх (Австрали Улс)
1.	84.10. Ratify the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights, aiming at the abolition of the death penalty, and render its legal practices consistent therewith (Canada)	84.10. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколыг соёрхон батлах, хууль зүйн практикийг түүнтэй уялдуулах (Канад Улс)

1. 84.11. Ratify the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights and amend its Criminal Code with a view to abolishing the capital punishment entirely (Slovakia)	84.11. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон батлах, цаазаар авах ялыг бүрмөсөн устгах үүднээс Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Словак Улс)
1. 84.12. Ratify the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights, and consequently amend its national legislation, in particular the Criminal Code (Italy)	84.12. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколыг соёрхон батлах, улмаар үндэсний хууль тогтоомж, ялангуяа Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах (Итали Улс)
1. 84.13. Swiftly accede to the Second Optional Protocol of the International Covenant on Civil and Political Rights (Switzerland)	84.13. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт II протоколд даруй нэгдэн орох (Швейцари Улс)
1. 84.14. Intensify its effort to harmonize national legislation with international standards, including by providing more training for judicial and law enforcement officials with a view to ensuring more effective application of international standards (Malaysia)	84.14. Үндэсний хууль тогтоомжийг олон улсын стандартад уялдуулах, олон улсын стандартыг илүү үр дүнтэй хэрэглэх үүднээс шүүгчид болон хууль хяналтын ажилтнуудад сургалт түлхүү явуулах (Малайз Улс)
1. 84.15. Continue harmonizing its domestic legislation in conformity with the Convention on the Rights of the Child, introduce legislation to prevent and end all forms of corporal punishment, and adopt effective measures for preventing children under the age of 18 from being involved in hazardous work (Italy)	84.15. Хүүхдийн эрхийн конвенцтой дотоодын хууль тогтоомжийг уялдуулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах, бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, ийм шийтгэлийг устгах, 18 нас хүрээгүй хүүхдээр аюултай ажил хийлгэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Итали Улс)
1. 84.16. Adopt laws and mechanisms essential to protecting human rights and freedoms, particularly in the following areas: protection of victims and witnesses; protection of human rights defenders; provisions on ensuring citizens' right to participation in decision-making; gender-based violence; independence of publishers; accountability of Parliament members; and civil society's right to participation in public interest litigation (Hungary)	84.16. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдол бүхий хууль, эрх зүйн акт, механизмыг баталж нэвтрүүлэх, ялангуяа, дараах салбарт: хохирогч, гэрчийг хамгаалах; хүний эрхийг хамгаалан тэмцэгчдийг хамгаалах; шийдвэр гаргах үйл явцад оролцох иргэний эрхийг хангах; жендэрт суурилсан хүчирхийлэл; хэвлэн нийтлэгчдийн бие даасан байдал; УИХ-ын гишүүдийн хариуцлага; нийтийн ашиг сонирхол бүхий хэрэг, маргаанд иргэний нийгэм оролцох эрх (Унгар Улс)
1. 84.17. Enact broad anti-discrimination legislation that explicitly prohibits discrimination based on sexual orientation and gender identity (Canada)	84.17. Бэлгийн чиг хандлага, жендэрийн байдлаар алагчилахыг илэрхий хориглосон, алагчилах явдлын эсрэг өргөн хүрээтэй хууль тогтоомж батлах (Канад Улс)
1. 84.18. Adopt legislation to prevent and end all forms of corporal punishment, in accordance with the Convention against Torture and other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (Brazil)	84.18. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн дагуу бие махбодийн шийтгэлийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, түүнийг устгах хууль тогтоомжийг батлах (Бразил Улс)
1. 84.19. Amend its Criminal Code to define torture as a crime in accordance with the definition in the Convention against Torture, including abolishing or revising article 44.1 of the Code so that there is no impunity for human rights violations (United Kingdom)	84.19. Хүний эрх зөрчих явдлыг хуулийн хариуцлагаас гадуур үлдээхгүйн үүднээс Эрүүгийн хуулийн 44.1 дэх хэсгийг хасах буюу өөрчлөх, мөн эрүү шүүлтийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэн гэмт хэргээр тодорхойлох чиглэлээр Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах (Их Британи Улс)
1. 84.20. In addition to initiatives undertaken by the Government for the elimination of torture and other cruel, inhuman or degrading treatment, bring national legislation into line with the Convention against Torture, particularly	84.20. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах явдлыг устгах зорилгоор хэрэгжүүлсэн санаачилгуудын хажуугаар үндэсний хууль тогтоомжийг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид, ялангуяа эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг уялдуулан

	with respect to the proper definition of the crime of torture (Mexico)	нийцүүлэх (Мексик Улс)
1.	84.21. Take steps to remedy the shortcomings related to the definition of torture and to the Criminal Procedure Code, which did not ensure that evidence obtained from torture is not invoked in any legal proceedings, to ensure conformity with the provisions of the Convention against Torture (Ghana)	84.21. Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн заалтуудад нийцүүлэх зорилгоор эрүү шүүлтийн тодорхойлолттой холбоотой дутагдал, мөн эрүү шүүлтийн дүнд олж цуглуулсан нотлох баримтыг аливаа шүүн таслах ажиллагаанд хэрэглэхгүй байх явдлыг хангаагүй Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дутагдлаа арилгах арга хэмжээ авах (Гана Улс)
1.	84.22. Amend the relevant legislation to bring the definition of torture into line with the Convention against Torture, and ensure that evidence obtained from torture is not invoked in any proceedings (Netherlands)	84.22. Эрүү шүүлтийн тодорхойлолтыг Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцид нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн эрүү шүүлтийн дүнд олж цуглуулсан нотлох баримтыг аливаа шүүн таслах ажиллагаанд хэрэглэхгүй байх явдлыг хангах (Нидерланд Улс)
1.	84.23. Adopt an anti-trafficking law to protect and assist victims of such criminal and clandestine activities (Indonesia)	84.23. Хүн худалдаалах далд бөгөөд гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанаас хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслах зорилгоор хүний наймааны эсрэг хууль батлах (Индонез Улс)
1.	84.24. Enact specific and comprehensive national legislation on trafficking providing for a national oversight mechanism (Poland)	84.24. Хүний наймааны эсрэг үндэсний хяналтын механизмыг бүрдүүлсэн хүн худалдаалахтай тэмцэх үндэсний тусгай, цогц хууль тогтоомж батлах (Польш Улс)
1.	84.25. Strengthen domestic legislation to protect victims and witnesses of human trafficking (Australia)	84.25. Хүний наймааны хохирогч болон гэрчүүдийг хамгаалах дотоодын хууль тогтоомжийг сайжруулах (Австрали Улс)
1.	84.26. Uphold its commitment to strengthen the national mechanism for the protection and promotion of children's rights (Islamic Republic of Iran)	84.26. Хүүхдийн эрхийг хамгаалж, дэмжих үндэсний механизмыг бэхжүүлэх чиглэлээрх үүрэг амлалтаа үргэлжлүүлэн биелүүлэх (Лалын Бүгд Найрамдах Иран Улс)
1.	84.27. Step up the efforts aimed at the adoption of the new 10-year National Programme on Strengthening Child Development and Protection (Algeria)	84.27. Шинээр 10 жилийн хугацаатай Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөрийг батлах талаар хүчин чармайлт гаргах (Алжир Улс)
1.	84.28. Successfully implement its plan of action for the period 2008-2012, which was adopted by the Government with a view to the implementation of the Convention on the Rights of Persons with Disabilities (Russian Federation)	84.28. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газраас баталсан 2008-2012 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэх (ОХУ)
1.	84.29. Ensure that all human rights initiatives stipulated in the National Plan of Action are implemented and monitored in an effective way (Indonesia)	84.29. Үндэсний Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүний эрхийн бүх санаачилгыг үр дүнтэйгээр хэрэгжүүлж, хянах (Индонез Улс)
1.	84.30. Channel its efforts into implementing poverty-alleviation strategies, particularly in suburban and rural areas (Indonesia)	84.30. Ядуурлыг (ялангуяа хотын зах хэсэг болон хөдөө, орон нутагт) арилгах стратегийг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргах (Индонез Улс)
1.	84.31. Continue to push forward its human rights cause in the light of its national conditions, especially by giving priority to economic development, poverty alleviation and protection of the rights of vulnerable groups (China)	84.31. Үндэсний нөхцөл байдлыг харгалзан, ялангуяа эдийн засгийн хөгжил, ядуурлыг арилгах, нийгмийн эмзэг бүлгийн эрхийг хамгаалахыг нэн тэргүүнд анхааран хүний эрхийн төлөө үйл хэргээ үргэлжлүүлэн урагшлуулах (БНХАУ)
1.	84.32. Make its procedures and decisions more transparent, and limit recourse to the law on State secrecy for corruption crimes, thus allowing monitoring bodies' independence and access in order to ensure that sanctions	84.32. Авлигын гэмт хэргийг Төрийн нууцын тухай хуулийн хүрээнд хамааруулах асуудлыг хязгаарлаж, үйл ажиллагаа, шийдвэрийг илүү ил тод болгох, улмаар холбогдох шийтгэлийг бүрэн хэрэгжүүлэх үүднээс хяналтын байгууллагуудын бие даасан байдлыг хангах,

	are fully applied (Switzerland)	ийм үйл ажиллагаанд нэвтрэх боломжийг эдгээр байгууллагад олгох (Швейцари Улс)
1.	84.33. Pay more attention to providing better treatment for foreigners (Republic of Korea)	84.33. Гадаадын иргэдэд хандах хандлага, үзүүлэх үйлчилгээг сайжруулахад түлхүү анхаарах (БНСУ)
1.	84.34. Put in place structures to ensure that Government and Parliamentary decision-making processes are transparent and that public legislative hearings take place (United Kingdom)	84.34. УИХ болон Засгийн газрын шийдвэр гаргах үйл явцыг ил тод болгох, хууль тогтоомжийг олон нийтээр хэлэлцүүлэх явдлыг хангах бүтэц, зохион байгуулалтыг бий болгох (Их Британи Улс)
1.	84.35. Ensure a participatory and inclusive process with civil society in the implementation of the universal periodic review recommendations, including organizations representing minorities (Norway)	84.35. Үндэсний ээлжит хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд иргэний нийгмийн, түүний дотор цөөнхийг төлөөлж буй байгууллагуудын оролцоог хангах (Норвеги Улс)
1.	84.36. Involve domestic human rights organizations in the follow-up to this review and in the implementation of its National Human Rights Action Plan (United Kingdom)	84.36. Энэхүү хэлэлцүүлгийн мөрөөр хэрэгжүүлэх болон Хүний эрхийн Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дотоодын хүний эрхийн байгууллагуудыг хамруулах (Их Британи Улс)
1.	84.37. For the protection of the rights of persons with disabilities, the participation of all relevant organizations is vital in order to promote their rights as well as the infrastructural and psychological environment are much needed (Kazakhstan)	84.37. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зорилгоор тэдний эрхийг дэмжихийн тулд холбогдох бүх байгууллагыг оролцуулах явдал амин чухал бөгөөд дэд бүтцийн болон сэтгэл зүйн орчинг бүрдүүлэх шаардлагатай (Казахстан Улс)
1.	84.38. Undertake special measures concerning employment, social welfare and protection of the rights of vulnerable groups, in particular women and persons with disabilities (Islamic Republic of Iran)	84.38. Нийгмийн эмзэг бүлгийн, ялангуяа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, ажил эрхлэлт, нийгмийн хамгааллын талаар тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлэх (Лалын Бүгд Найрамдах Иран Улс)
1.	84.39. Demonstrate improvements in submitting its reports in a regular manner to the treaty bodies, particularly for the International Covenant on Civil and Political Rights and the International Covenant on Economic, Social and Cultural Rights, reports under which have been overdue since 2003 (France)	84.39. Гэрээний байгууллагуудад илтгэлээ тогтмол хүргүүлэх ажлыг сайжруулах, ялангуяа 2003 оноос хойш хугацаа хоцорч буй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн илтгэлийг хүргүүлэхэд анхаарах (Франц Улс)
1.	84.40. Finalize and submit the treaty body periodic reports as a matter of priority (Australia)	84.40. Гэрээний байгууллагад тогтмол хүргүүлэх илтгэлүүдээ эцэслэж, хүргүүлэхэд нэн тэргүүнд анхаарах (Австрали Улс)
1	84.41. Submit overdue reports to the United Nations treaty bodies as a matter of priority (Norway)	84.41. Хугацаа хоцорсон илтгэлүүдийг НҮБ-ын гэрээний байгууллагуудад хүргүүлэхэд нэн тэргүүний анхаарал хандуулах (Норвеги Улс)
1	84.42. Report regularly to all human rights treaty bodies (Slovenia)	84.42. Хүний эрхийн бүх гэрээний байгууллагуудад тайлангаа тогтмол хүргүүлэх (Словени Улс);
1	84.43. Extend an invitation to the Special Rapporteur on trafficking in persons, especially women and children (New Zealand)	84.43. Хүн худалдаалах, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалах асуудлаарх Тусгай илтгэгчийг урих (Шинэ Зеланд Улс)
1	84.44. Ensure a human rights culture, inter alia, by strengthening the anti-discriminatory legislative framework and ensuring its effective implementation (Norway)	84.44. Алагчилахын эсрэг хууль тогтоомжийг бэхжүүлж, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх зэрэг замаар хүний эрхийн соёлыг хангах (Норвеги Улс)
1	84.45. Take stronger measures to combat discrimination in both the public and private sectors while promoting greater women's participation at the highest levels of decision-making (United States)	84.45. Шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжихийн зэрэгцээ төрийн болон хувийн салбар дахь алагчилалтай тэмцэх илүү хатуу арга хэмжээг авч хэрэгжүүлэх (АНУ)

1	84.46. Adopt a draft law on gender equality and the establishment of an institutional mechanism responsible for the promotion of equality (Ghana)	84.46. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг баталж, эрх тэгш байдлыг хангах механизмыг бий болгох (Гана Улс)
1	84.47. Strengthen existing legal protections and enhance enforcement to combat discrimination against and mistreatment of women and girls (United States)	84.47. Эмэгтэйчүүд, охидтой зүй бусаар харьцах, тэднийг алагчилахтай тэмцэх талаар одоогийн эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлж, хэрэгжилтийг сайжруулах (АНУ)
1	84.48. Adopt expeditiously a law on gender equality, empower its National Committee on Gender Equality, and take appropriate measures to eliminate discrimination against women, hence promoting their advancement, with a particular focus on the most vulnerable groups, such as rural women (Slovakia)	84.48. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг шуурхай баталж, Жендэрийн тэгш байдлын Үндэсний хороонд холбогдох эрх хэмжээг олгох, мөн эмэгтэйчүүдийг, ялангуяа хөдөөгийн эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийг алагчилах явдлыг арилгах талаар зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх (Словак Улс)
1	84.49. Undertake effective measures to ensure the implementation of legislation guaranteeing the principle of non-discrimination, adopting a comprehensive strategy to eliminate all forms of discrimination, particularly on the basis of gender, and strengthen its efforts aimed at harmonizing its national legislation with ratified international instruments (Ukraine)	84.49. Алагчиллын бүх хэлбэрийг, ялангуяа жендэрт суурилсан алагчиллыг устгах цогц стратегийг батлах замаар үл алагчилах зарчмыг баталгаажуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үр дүнтэй арга хэмжээ авах, үндэсний хууль тогтоомжийг соёрхон баталсан олон улсын баримт бичгүүдтэй уялдуулах чиглэлээр хүчин чармайлтаа бэхжүүлэх (Украин Улс)
1	84.50. Develop policies favouring equal opportunities for women (Switzerland)	84.50. Эмэгтэйчүүдэд адил тэгш боломж олгоход чиглэсэн бодлого боловсруулах (Нидерланд Улс)
1	84.51. Ensure equal rights for women in the area of employment (Norway)	84.51. Ажил эрхлэлтийн салбарт эмэгтэйчүүдийн тэгш эрхийг хангах (Норвеги Улс)
1	84.52. Ensure equal pay for work of equal value (Norway)	84.52. Ижил үнэлгээтэй ажил гүйцэтгэсний төлөө ижил хэмжээний хөлс олгох явдлыг хангах (Норвеги Улс)
1	84.53. Strengthen maternity protection (Norway)	84.53. Эхчүүдийн хамгааллыг бэхжүүлэх (Норвеги Улс)
1	84.54. Strengthen efforts to address domestic and sexual violence (Norway)	84.54. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийг устгахад хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Норвеги Улс)
1	84.55. Ensure proper redress and protection for victims of such crimes (Norway)	84.55. Тийм гэмт хэргийн хохирогчдыг зохих ёсоор хамгаалах, нийгэмшүүлэх явдлыг хангах (Норвеги Улс)
1	84.56. Publicly condemn all forms of violence and discrimination based on sexual orientation, and investigate and prosecute all reported attacks and threats against individuals based on their sexual orientation (Netherlands)	84.56. Бэлгийн чиг баримжаагаар алагчилах, хүчирхийлэхийн бүх хэлбэрийг нээлттэй буруушааж, бэлгийн чиг баримжаанд суурилсан халдлага, заналхийллийн хэргийг мөрдөн шалгаж, яллах (Нидерланд Улс)
1	84.57. Develop its legislation with a view to effectively protecting the rights of LGBT persons, and discourage the development of discriminatory ideologies in the country through information and human rights education (Switzerland)	84.57. ЛГБТ хүмүүсийн эрхийг үр дүнтэй хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж боловсруулж, тус улсад ЛГБТ хүмүүсийг алагчилах үзлийг бий болгохыг хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар зогсоох (Швейцари Улс)
1	84.58. Ensure thorough and impartial investigations into all allegations of attacks and threats against individuals targeted because of their sexual orientation and gender identity, and bring to justice those responsible (Canada)	84.58. Бэлгийн чиг баримжаа буюу хүйсийн чиг баримжаанаас нь хамаарч хувь хүмүүст халдсан, заналхийлсэн хэргийг нарийвчлан, хараат бусаар мөрдөн шалгах явдлыг хангах, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх (Канад Улс)
1	84.59. Support the efforts to promote and protect the rights of vulnerable groups such as children, women, disabled persons and the elderly (Cuba)	84.59. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан зэрэг эмзэг бүлгийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих хүчин чармайлтыг дэмжих (Куба Улс)
1	84.60. Increase awareness regarding disability rights, and make all appropriate accommodations for disabled voters (United	84.60. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлж, тэдгээрийн сонгох эрхийг хэрэгжүүлэх бүх нөхцөлийг хангах (АНУ)

	States)	
1	84.61. Design and implement educational programmes for the gradual inclusion of students with disabilities in the education system (Slovenia)	84.61. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, сурагчдыг боловсролын системд алгуур нэвтрүүлэх зорилгоор боловсролын хөтөлбөрөө боловсруулж, хэрэгжүүлэх (Словени Улс)
1	84.62. Design and implement educational programmes promoting greater inclusiveness in classrooms (United States)	84.62. [Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг] анги танхимын хичээлд сургахыг нэмэгдүүлэхийг дэмжих боловсролын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх (АНУ)
1	84.63. Continue its efforts with a view to definitely abolishing the death penalty, and adhere to the Second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights, aiming at the abolition of the death penalty (France)	84.63. Цаазаар авах ялыг бүрмөсөн халах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орох (Франц Улс)
1	84.64. Continue to adopt measures with a view to abolishing the death penalty, in particular to ratify the second Optional Protocol to the International Covenant on Civil and Political Rights (Argentina)	84.64. Цаазаар авах ялыг халах арга хэмжээгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, ялангуяа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын цаазаар авах ялыг устгахад чиглэсэн нэмэлт II протоколыг сочрхон батлах (Аргентин Улс)
1	84.65. Maintain its moratorium on the use of the death penalty with a view to eventually abolishing it (Germany)	84.65. Цаазаар авах ялыг эцэслэн халах зорилгоор хоригоо хадгалах (Герман Улс)
1	84.66. Follow up on the positive development (the moratorium on the death penalty) by removing capital punishment from legislation (Norway)	84.66. Цаазаар авах ялыг хууль тогтоомжоосоо хасах замаар одоогийн нааштай явцын (цаазаар авах ялд хориг тавьсан) мөрөөр арга хэмжээ авах (Норвеги Улс)
1	84.67. Adopt and implement, as soon as possible, the new legislation on the abolition of the death penalty (Switzerland)	84.67. Цаазаар авах ялыг халах шинэ хууль тогтоомжийг аль болох түргэн баталж, хэрэгжүүлэх (Швейцари Улс)
1	84.68. Amend existing provisions in the Criminal Code with the aim of introducing a complete abolition of the death penalty (United Kingdom)	84.68. Цаазаар авах ялыг бүрмөсөн устгах зорилгоор Эрүүгийн хуулийн одоогийн заалтыг өөрчлөх (Их Британи Улс)
1	84.69. Amend its legislation in order to abolish the death penalty (New Zealand)	84.69. Цаазаар авах ялыг халах зорилгоор хууль тогтоомждоо өөрчлөлт оруулах (Шинэ Зеланд Улс)
1	84.70. Ensure that the de facto moratorium declared by the President of Mongolia in January 2010 is incorporated into legislation with a view to completely abolishing the death penalty (Spain)	84.70. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 1 дүгээр сард зарласан de facto хоригийг цаазаар авах ялыг бүрмөсөн устгах зорилгоор хууль тогтоомжид тусгах явдлыг хангах (Испани Улс)
1	84.71. Establish awareness-raising programmes addressed to law enforcement forces aimed at preventing torture and other cruel, inhuman or degrading treatment, as well as efficient investigative mechanisms in order to fight against impunity in this regard (France)	84.71. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдлэг дээшлүүлэх хөтөлбөрийг бий болгох, мөн ийм хэргийг хуулийн хариуцлагаас гадуур үлдээхтэй тэмцэх чиглэлээр мөрдөн шалгах үр дүнтэй механизмыг бүрдүүлэх (Франц Улс)
1	84.72. Pay due attention to the implementation of recommendations made by the Special Rapporteur on Torture (Kazakhstan)	84.72. Эрүүдэн шүүхийн асуудлаарх тусгай илтгэгчийн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд зохих анхаарал хандуулах (Казахстан Улс)
1	84.73. Apply mandatory training of police in the appropriate use of force (Canada)	84.73. Хүч хэрэглэх эрх хэмжээг зохистойгоор хэрэгжүүлэх талаар цагдаа нарт сургалт заавал зохион байгуулж байх (Канад Улс)
1	84.74. Take effective measures to combat domestic violence (Azerbaijan)	84.74. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үр дүнтэй арга хэмжээ авах (Азербайжан Улс)
1	84.75. Implement legislation which provides for the investigation of violence against women, and the prosecution and punishment of the perpetrators of such violence (New Zealand)	84.75. Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн хэргийг мөрдөн шалгах, ийм хүчирхийлэл үйлдэгчдийг яллах, шийтгэх заалт бүхий хууль тогтоомж хэрэгжүүлэх (Шинэ Зеланд Улс)

1	84.76. Give high priority to the enforcement of the Law on Fighting against Domestic Violence in order to ensure that victims have access to adequate means of protection and compensation (Portugal)	84.76. Хамгаалуулах, нөхөн төлбөр авах боломжийг хохирогчид олгох зорилгоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгөх (Португали Улс)
1	84.77. Take measures to guarantee effective access for women victims of gender-based violence to justice, redress and protection (Brazil)	84.77. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч эмэгтэйчүүдэд шударга шүүхээр шүүлгэх, нийгэмших, хамгаалуулах боломжийг үр дүнтэйгээр олгох баталгааг хангах арга хэмжээ авах (Бразил Улс)
1	84.78. Adopt the necessary measures and introduce the necessary amendments to the 2005 law on gender violence to ensure its effectiveness and to clearly define the sentences for offenders (Spain)	84.78. Жендэрийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 2005 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, шаардлагатай арга хэмжээ авах замаар хуулийн үр дүнг хангах, хууль зөрчигчдэд ногдуулах ялыг тодорхой тусгах (Испани Улс)
1	84.79. Continue to work to improve conditions in its prisons, including through the implementation of the United Nations Body of Principles for the Protection of All Persons under Any Form of Detention and Imprisonment, and the United Nations Standard Minimum Rules for the Treatment of Prisoners (New Zealand)	84.79. Хорих ял эдэлж буй болон цагдан хоригдож буй хүмүүсийг хамгаалах НҮБ-ын зарчим, Хоригдлуудтой харьцах НҮБ-ын наад захын жишиг зэргийг хэрэгжүүлэх болон бусад замаар хорих байгууллагуудын нөхцөлийг сайжруулах чиглэлээр ажиллах (Шинэ Зеланд Улс)
1	84.80. Undertake more efforts to effectively combat the human trafficking phenomenon (Azerbaijan)	84.80. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхийн тулд илүү хүчин чармайлт гаргах (Азербайжан Улс)
1	84.81. Ensure that adequate mechanisms are in place for the rehabilitation and social integration of women and girls who have been victims of trafficking (Poland)	84.81. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, охидыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх зохих механизмыг бүрдүүлэх (Польш Улс)
1	84.82. Expand the national programme on the prevention of human trafficking, particularly the use of children and women for sexual purposes, with a view to dealing with all violations of provisions of the Palermo Protocol, in line with the recommendations of the Committee on the Rights of the Child (Mexico)	84.82. Палермогийн протоколын заалтыг зөрчсөнийг засах зорилгоор, Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан зөвлөмжид нийцүүлэн хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх (Мексик Улс)
1	84.83. Adopt an approach of non-criminalization of the victims of human trafficking, which provides for compensation for victims and their reintegration into society (Mexico)	84.83. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг гэмт хэрэгт татахгүй байх, хохирогчдод нөхөн төлбөр олгох, нийгэмшүүлэх хандлагыг хэрэгжүүлэх (Мексик Улс)
1	84.84. Increase efforts to prosecute sex and labour trafficking offenders, as well as assist and protect victims of trafficking (United States)	84.84. Бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалагчдыг яллах, хохирогчдыг хамгаалж, тусламж үзүүлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (АНУ)
1	84.85. Further develop, enhance and expand awareness-raising campaigns to counter human trafficking (Canada)	84.85. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажлыг хөгжүүлэх, нэмэгдүүлэх, өргөжүүлэх (Канад Улс)
1	84.86. Continue its policies against trafficking (Germany)	84.86. Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Герман Улс)
1	84.87. Strengthen its institutional capacity for investigation of cases of human trafficking and prosecution of perpetrators (Canada)	84.87. Хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах, гэмт хэрэгтнийг яллах талаар институцийн (зохион байгуулалт, боловсон хүчин, нөөц хөрөнгө) чадавхийг бэхжүүлэх (Канад Улс)
1	84.88. Continue its efforts to ensure effective protection of minors and women against sexual exploitation (Czech Republic)	84.88. Насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөөс үр дүнтэй хамгаалах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (БНЧУ)
1	84.89. Adopt specific measures for the protection of minors and women who have become victims of sexual exploitation, and	84.89. Бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон насанд хүрээгүй хүмүүс, эмэгтэйчүүдийг хамгаалах тусгай арга хэмжээг хэрэгжүүлж, хохирогчдол тусламж үзүүлэх, нэр

	ensure assistance to, restore the reputation of and provide rehabilitation for those victims (Czech Republic)	хүндийг нь сэргээх болон тэднийг нөхөн сэргээх (БНЧУ)
1	84.90. Strengthen measures to prevent sexual exploitation of children, ensure prompt investigation of allegations of exploitation and sexual abuse, and punish perpetrators (Argentina)	84.90. Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх арга хэмжээг бэхжүүлж, бэлгийн мөлжлөг, ёс бус харьцааны хэргийг шуурхай мөрдөн шалгаж, гэмт хэрэгтнийг шийтгэх (Аргентин Улс)
1	84.91. Take the necessary steps, as soon as possible, to address the issues of inadequate protection of children from sexual exploitation as well as the insufficient investigation of the perpetrators of sexual crimes against children and the consequent low ratio of prosecutions against perpetrators of sexual crimes against children (Japan)	84.91. Хүүхдийг бэлгийн мөлжлөгөөс зохих ёсоор хамгаалахгүй байгаа, хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн гэмт хэргийг хангалттай мөрдөн шалгахгүй байгаа, түүнчлэн хүүхдийн эсрэг бэлгийн гэмт хэрэгт яллагдагсдын тоо ийм хэрэг үйлдэгсдийн тооноос бага байгаа зэрэг асуудлыг шийдвэрлэх талаар шаардлагатай арга хэмжээг аль болох түргэн авч хэрэгжүүлэх (Япон Улс)
1	84.92. Implement effective measures to tackle child labour (Azerbaijan)	84.92. Хүүхдийн хөдөлмөрийг зогсоох талаар үр дүнтэй арга хэмжээ авах (Азербайжан Улс)
1	84.93. Continue efforts to improve the situation of children and, in this context, intensify the efforts to effectively prevent child labour (Germany)	84.93. Хүүхдийн нөхцөл байдлыг сайжруулах хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, үүний хүрээнд хүүхдийн хөдөлмөрөөс үр дүнтэй сэргийлэхэд хүчин чармайлтаа эрчимжүүлэх (Герман Улс)
1	84.94. Further strengthen the law enforcement and judicial system in the effort to address impunity and prevent the incidence of trafficking and domestic violence as well as the sexual abuse of women and girls (Malaysia)	84.94. Хүн худалдаалах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэл, эмэгтэйчүүд, охидын эсрэг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, ийм хэргийг хуулийн хариуцлагаас гадуур үдээхийг зогсоох чиглэлээр хууль хэрэгжүүлэх болон шүүх тогтолцоог бэхжүүлж сайжруулах (Малайз Улс)
1	84.95. Strengthen the Special Investigation Unit of the State General Prosecutor's Office to ensure thorough and independent investigations of all allegations of police violence (Canada)	84.95. Цагдаагийн албан хаагчдын үйлдсэн хүчирхийллийн гэмт хэргийг нягт бөгөөд хараат бусаар мөрдөн шалгах зорилгоор Улсын ерөнхий прокурорын газрын Мөрдөн байцаах хэлтсийг бэхжүүлэх (Канад Улс)
1	84.96. Ensure thorough and impartial investigations into all allegations of attacks and threats against individuals targeted because of their sexual orientation, as in the case of LGBT individuals, and bring to justice those responsible in accordance with international standards of fair trial (Sweden)	84.96. Бэлгийн чиг баримжаанаас нь хамааран, тухайлбал ЛГБТ хүмүүсийг заналхийлсэн, халдсан бүх хэргийг нягт бөгөөд хараат бусаар мөрдөн шалгаж, шударга шүүхийн олон улсын жишгийн дагуу буруутай этгээдийг шийтгэх (Швед Улс)
1	84.97. Combat impunity in cases of torture (Germany)	84.97. Эрүүдэн шүүсэн хэрэгт хуулийн хариуцлагаас гадуур үлдэхтэй тэмцэх (Герман Улс)
1	84.98. Establish clear national guidelines that allow all faiths equal access to registration (United States)	84.98. Бүх шашин шүтлэгийг тэгш бүртгэх дотоодын тодорхой журам бий болгох (АНУ)
1	84.99. Promote the rights to freedom of expression, association and assembly without discrimination of members of the LGBT community (Sweden)	84.99. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг ЛГБТ хүмүүсийг алагчилахгүйгээр хангах (Швед Улс)
1	84.100. Introduce appropriate measures necessary to allow persons with disabilities to exercise their right to vote (Slovakia)	84.100. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонгох эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зохих арга хэмжээ авах (Словак Улс)
1	84.101. Take effective measures to ensure that persons with disabilities and detained persons can exercise their right to vote (Islamic Republic of Iran)	84.101. Хөгжлийн бэрхшээлтэй болон цагдан хоригдсон хүмүүсийн сонгох эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үр дүнтэй арга хэмжээ авах (Лалын БН Иран Улс);
1	84.102. Improve the level of participation of women in the decision-making process (Algeria)	84.102. Шийдвэр гаргах явцад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх (Алжир Улс)

1	84.103. Continue its efforts to reduce poverty and food insecurity (Azerbaijan)	84.103. Ядуурлыг бууруулах, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх (Азербайджан Улс)
1	84.104. Strengthen efforts to combat malnutrition and diseases such as tuberculosis (Bangladesh)	84.104. Тэжээлийн дутагдал болон сүрьеэ зэрэг өвчинтэй тэмцэх хүчин чармайлтаа сайжруулах (Бангладеш Улс)
1	84.105. Ensure access to health care, adequate housing, education and safe drinking water and sanitation for all, especially people living in “ger” districts (Slovenia)	84.105. Нийт хүн ам, ялангуяа гэр хороололд оршин сууж буй хүмүүст эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах, зохих орон сууцтай байх, боловсрол эзэмших боломжийг олгох, ундны усны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах (Словени Улс)
1	84.106. Continue taking appropriate measures to provide a healthy and safe environment for its citizens (Pakistan)	84.106. Иргэддээ эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх арга хэмжээгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Пакистан Улс)
1	84.107. Consider giving a greater role to the private sector in developing the national education and health system (Islamic Republic of Iran)	84.107. Үндэсний боловсролын болон эрүүл мэндийн тогтолцоог хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог түлхүү нэмэгдүүлэхэд анхаарах (Лалын БН Иран Улс)
1	84.108. Step up efforts to improve and conserve the environment, including by strengthening the relevant laws and providing the public with the necessary information, education and awareness regarding the impacts of environmental pollution and degradation (Malaysia)	84.108. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үр нөлөөг сайжруулах, үүний хүрээнд холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох, байгаль орчны бохирдол, муудалтын үр дагаварын талаар нийтэд мэдээлэл, боловсрол, мэдлэг олгох (Малайз Улс)
1	84.109. Take further appropriate measures, including the adoption of a national plan of action to tackle challenges resulting from global warming or climate change and adverse human activities, in particular with regard to sanitary systems (Islamic Republic of Iran)	84.109. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй, ялангуяа эрүүл ахуйн тогтолцооны талаарх тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд үйл ажиллагааны үндэсний хөтөлбөр боловсруулах зэргээр цаашид зохих арга хэмжээ авах (Иран Улс)
1	84.110. Apply programmes and means to improve the enjoyment of the right to education and the right to health (Cuba)	84.110. Иргэдийн сурч боловсрох эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг хангах хөтөлбөр, арга хэрэгслийг хэрэгжүүлэх (Куба Улс)
1	84.111. Take additional measures to fight against dropping out of school, particularly among boys (Algeria)	84.111. Сургуулиас завсардах (ялангуяа эрэгтэй хүүхдүүд)-ын эсрэг нэмэлт арга хэмжээ авах (Алжир Улс)
1	84.112. Intensify its efforts to reinforce the human rights issue in school curricula (Turkey)	84.112. Сургуулийн боловсролын хөтөлбөрт хүний эрхийн сэдвийг тусгах хүчин чармайлтаа эрчимжүүлэх (Турк Улс)
1	84.113. Provide adequate minority protection for indigenous and tribal groups (Slovenia)	84.113. Уугуул иргэд болон омог, отгоор амьдардаг хүмүүст зохих хамгаалалт үзүүлэх (Словени Улс)
1	84.114. Continue the strategies and the plans for the social and economic development of the country (Cuba)	84.114. Улс орны нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөөг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх (Куба Улс)
1	84.115. Continue to fight to overcome its challenges with the assistance of the international community (Bangladesh)	84.115. Олон улсын хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр бэрхшээлтэй асуудлыг даван туулах талаар үргэлжлүүлэн ажиллах (Бангладеш Улс)
1	84.116. Request technical assistance and cooperation, as deemed appropriate, from the international community, including the relevant United Nations and specialized agencies, with a view to ensuring the promotion and protection of the full spectrum of the human rights of its people (Malaysia)	84.116. Ард түмнийхээ бүх төрлийн хүний эрхийг бүрэн хамгаалах, дэмжих зорилгоор НҮБ болон түүний төрөлжсөн байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгээс зохих техникийн туслалцаа, хамтын ажиллагаа хүсэх (Малайз Улс)
1	84.117. Seek international assistance to combat child labour, such as through the International Labour Organization (Brazil)	84.117. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэхэд Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэргээр дамжуулан олон улсын туслалцаа эрэлхийлэх, хүсэх (Бразил Улс)

1	84.118. Seek technical cooperation at the international level in order to respond in a timely manner to the challenge of providing a healthy and safe environment for its citizens (Pakistan)	84.118. Иргэдийнхээ эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг шуурхай хангах үүднээс олон улсын түвшний техникийн хамтын ажиллагааг эрэлхийлэх (Пакистан Улс)
1	86.4. Consider accepting individual complaints mechanisms such as those provided for in the International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination, the Convention against Torture and other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, the International Covenant on Civil and Political Rights and the Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women (Brazil)	86.4. Арьс үндсээр алагчилах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийн алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэгт тусгагдсан хувь хүний гомдол хянан шийдвэрлэх механизмыг хүлээж авах боломжийг судлах (Бразил Улс)
1	86.5. Adopt quick and effective measures, as well as necessary legislation, in order to explicitly prohibit, prevent, punish and abolish discrimination on any grounds, including on the basis of HIV/AIDS status (Mexico)	86.5. Аливаа үндэслэлээр, түүний дотор ХДХВ/ДОХ-ын байдлаар алагчилах үзлийг шууд хориглох, урьдчилан сэргийлэх, шийтгэх, устгах зорилгоор үр дүнтэй арга хэмжээг түргэн авч хэрэгжүүлэх, шаардлагатай хууль тогтоомжийг батлах (Мексик Улс)
1	86.6. The National Human Rights Commission of Mongolia, which has an “A” status accreditation, should play a decisive role in the exercise of drafting a gender equality law as well as during its implementation (Hungary)	86.6. “А” үнэлгээтэйгээр магадлан итгэмжлэгдсэн ХЭҮК нь жендэрийн тэгш байдлын тухай хууль боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэвэл зохино (Унгар Улс)
1	86.7. Include women in high-level decision-making positions (Norway)	86.7. Шийдвэр гаргах дээд албан тушаалд эмэгтэйчүүдийг оролцуулах (Норвеги Улс)
1	86.8. Amend the provisions of the Criminal Code and eliminate legal provisions and practices by public authorities, including possible practices of harassment and bullying by the police forces, which lead to discrimination based on sexual orientation and gender identity (Spain)	86.8. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, бэлгийн чиг баримжаа болон хүйсийн чиг баримжаагаар алагчилахад хүргэж буй цагдаагийн хүчний хүч хэрэглэх, доромжлон хандах зэрэг төрийн байгууллагын практик, хуулийн заалтыг устгах (Испани Улс)
1	86.9. Protect victims by defining hate crimes as crimes under criminal laws (Canada)	86.9. Эрүүгийн хууль тогтоомжид үзэн ядах гэмт хэргийг тодорхойлон оруулах замаар тийм гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах (Канад Улс)
1	86.10. Declassify death penalty sentences imposed in the past as a State secret, with the aim of providing the families of those who were executed with information on their relatives sentenced to death (Czech Republic)	86.10. Цаазаар авах ялаар шийтгэгдсэн хүмүүсийн талаарх мэдээллийг ар гэрийнхэнд нь өгөх зорилгоор өнгөрсөн хугацаанд ногдуулсан цаазаар авах ялыг төрийн нууцад хамааруулсныг цуцлах (БНЧУ)
1	86.11. Remove the classification of information on the death penalty as a State secret, and provide statistics and information related to death sentences and executions (Netherlands)	86.11. Цаазаар авах ял ногдуулж, гүйцэтгэсэнтэй холбоотой мэдээллийг төрийн нууцын зэрэглэлд хамааруулах явдлыг арилгаж, цаазаар авах ял, түүний шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл, статистик тоо баримтыг гаргах (Нидерланд Улс)